

ИНВЕСКОР ББСБ ХК-ИЙН 2026 ОНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН

ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Хуралдсан өдөр: 2026 оны 4 сарын 29-ний өдөр

Хуралдсан цаг: 14:00 минутад эхлэв.

Хурласан газар: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Парисын гудамж, Ай Си Тауэр барилга, 5 давхарт танхимаар болон Инвескор апп, веб хуудсаар дамжуулан цахимаар хосолсон хэлбэрээр зохион байгуулж байна.

Хурлын ирц: Энгийн хувьцаа эзэмшигчдийн 87.41 хувь

Саналын эрхийн тоо: 66,211,025 ширхэг энгийн хувьцаа

Хуралд оролцоогүй: 12.59% (9,533,256 ширхэг энгийн хувьцаа)

Хурлын дарга: Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Д.Баясгалан

ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга: Б.Буд

Тооллогын комиссын дарга: Б.Энхжин

Тооллогын комиссын гишүүд: М.Энхзул

Э.Цолмон

Хэлэлцсэн асуудал:

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны үйл ажиллагааны төсвийг батлах;
3. Компанийн хувьцаа хуваах шийдвэрийг шинэчлэн батлах, Компанийн дүрмийн нэмэлт өөрчлөлт батлах тухай;

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга Б.Буд эхлүүлэв.

ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга Б.Буд:

Хурлын ирцийн бүртгэл 14:00 цагт хаагдсаныг мэдэгдэж байна. Өнөөдрийн хурлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга Б.Буд миний бие модератороор удирдан явуулна. Хурал нь нийт хувьцаа эзэмшигчдийн оролцоог хангах зорилгоор танхим болон цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулагдаж байна.

Хуралд оролцох дэг, санамжийг танилцуулав.

Тооллогын комиссын дарга Б.Энхжин: хурлын ирцийн мэдээг танилцуулав.

2026 оны 4 сарын 29-ний өдрийн хурлын ирцийг танилцуулъя. Хуралд оролцож буй хувьцааны тоо 66,211,025 ширхэг, энэ нь нийт саналын эрх бүхий хувьцаа болох 75,744,281 ширхэг энгийн

хувьцааны 87.41 хувийг бүрдүүлж байна. Иймд Компанийн тухай хуулийн дагуу хурал хүчин төгөлдөр гэж үзэж байна.

Хуралд оролцогчид

- Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга: Д.Баясгалан
- Гүйцэтгэх захирал: Д.Оролмаа
- Санхүү шинжилгээ, төлөвлөлтийн газрын захирал: Г.Цэрэннадмид
- Санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийж гүйцэтгэсэн: Эрнст энд Янг Монголия аудит ХХК
- Хувьцаа эзэмшигчдийн хурлын Хөндлөнгийн аудит: Ингүүмэл Жаргалант Аудит ХХК-ийн төлөөлөгчид оролцож байна.

ХУРЛЫН НЭЭЛТ: ТУЗ-ИЙН ДАРГА Д.БАЯСГАЛАН

2026 оны ээлжит ХЭХ эхэлж байгааг зарлаж байна. Өнөөдрийн хуралдаа танхимаар хүрэлцэн ирж оролцож буй нийт хувьцаа эзэмшигч нартаа болон зайнаас онлайнаар оролцож байгаа нийт хувьцаа эз хувьцаа эзэмшигч нартаа баярлалаа. Хурлын хөтөлбөр нь танилцуулах болон санал хураалт хийх асуудлаас бүрдэнэ.

Хурлын дэг, хурлаар танилцах, хэлэлцэх асуудлуудыг танилцуулав.

2026 онд компанийн удирдлагад өөрчлөлт орсон:

- Д.Баясгалан: Гүйцэтгэх захирлаар 10 жил ажилласныхаа дараа ТУЗ-ийн дарга болон томилогдож,
- Д.Оролмаа: Покет компанийн гүйцэтгэх захирлын албыг хашиж байсан бол одоо Инвескор ББСБ-ын Гүйцэтгэх захирлаар томилогдон ажиллаж байна.

Инвескор ББСБ ХК-ийн Гүйцэтгэх захирал Д.Оролмаа

Та бүхэнд 2025 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг танилцуулж байна.

Компанийн бүтэц: Инвескор ББСБ ХК нь Монголын Хөрөнгийн Биржийн I ангилалд бүртгэлтэй нээлттэй компани бөгөөд нийт хувьцааны 19.51%-ийг олон нийт эзэмшиж, үлдсэн 80.49%-ийг Эс Ай Би Жэй Капитал ХХК эзэмшиж байна. Группийн бүтцийг авч үзвэл, Лондонгийн хөрөнгийн биржид бүртгэлтэй Invescore Financial Group нь Сингапурт бүртгэлтэй ICFG компаниар дамжуулан Эс Ай Би Жэй Капитал ХХК-ийг 100% эзэмшдэг.

Компанийн охин болон хараат компаниуд Монгол, Киргиз, Казахстан, Узбекистан зэрэг зах зээлд үйл ажиллагаа явуулж байна. Монголд Покет ББСБ нь финтек технологид суурилсан платформуур дамжуулан хэрэглэгчдэд санхүүгийн цогц үйлчилгээ хүргэж байгаа бол Киргиз, Казахстан, Узбекистан дахь компаниуд тухайн улсын зах зээлийн онцлогт нийцсэн уламжлалт болон дижитал санхүүгийн үйлчилгээг үзүүлж байна. Мөн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зорилготой тусгай зориулалтын компаниудыг байгуулан ажиллаж байна.

2025 оны амжилт: 2025 он бол компанийн хувьд өсөлт, тэлэлтийн чухал жил байлаа. Бид Монгол Улсын ТОП-100 аж ахуйн нэгжийн жагсаалтад анх удаа багтаж, тогтвортой санхүүжилтийн чиглэлээр салбартаа онцлох байгууллагаар шалгарсан. Мөн манай охин компани Покет нь нийгмийн хариуцлагын чиглэлээр хэрэгжүүлсэн төслүүдийнхээ үр дүнд “Шилдэг нийгмийн хариуцлага хэрэгжүүлэгч байгууллага”-аар шалгарсан. Үүний нэг тод жишээ нь ЦЕГ-ын Кибер гэмт хэрэгтэй тэмцэх газартай хамтран байгуулсан “Police Support Zone” бөгөөд уг төвөөр дамжуулан иргэдэд цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, зөвлөгөөг хүргэж байна.

- **Санхүүжилтийн хувьд** бид 2025 онд нийт \$58 саяын эх үүсвэрийг олон улсын зах зээлээс татан төвлөрүүлсэн. Үүнд Нидерландын хөгжлийн сангаас \$20 саяын урт хугацааны санхүүжилт, Triple Jump байгууллагаас \$5 саяын зээл, мөн Покет ББСБ дээр хэрэгжсэн Helicar сангийн \$25 саяын хөрөнгө оруулалт багтаж байна. Эдгээр санхүүжилт нь ногоон зээл, ЖДҮ-ийн санхүүжилт болон финтек үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэж байна.
- **Зээлийн үйл ажиллагааны хувьд** бид бичил, жижиг, дунд бизнесийг дэмжих бодлогын хүрээнд “Боломжоо тэл” аяныг хэрэгжүүлж, нийт ₮33 тэрбумын бизнесийн зээлийг олгосон. Мөн ногоон санхүүжилтийг дэмжих зорилгоор эрчим хүчний хэмнэлттэй тоног төхөөрөмжид чиглэсэн зээлийн бүтээгдэхүүнүүдийг зах зээлд нэвтрүүлж, ₮16 тэрбумын санхүүжилтийг олгосон байна.
- **Тэлэлт:** Орон нутгийн бизнесийн эрэлт өсөж байгаатай холбоотойгоор салбарын тоогоо нэмж, 2025 оны эцсийн байдлаар Улаанбаатарт 14, орон нутагт 4 салбартайгаар нийт 18 салбартайгаар үйл ажиллагаа явуулж байна.
- **Охин компаниудын гүйцэтгэл:** Покет ББСБ 273 мянган хэрэглэгчтэй болж, ₮417 тэрбумын зээлийн багцыг удирдаж байна. Киргизстан дахь үйл ажиллагаа тогтвортой өсөж, зээлийн багц ₮67.5 тэрбумд хүрсэн бол Казахстан дахь үйл ажиллагаа эрчимтэй тэлж, зээлийн багц 230% өссөн байна.

Санхүүгийн үр дүн

2025 оны эцэст компанийн нийт актив ₮1.1 их наядад хүрч 23% өссөн бол цэвэр зээлийн багц ₮883 тэрбум болж 20% өссөн. Нийт орлого ₮351 тэрбум болж 41% өссөн бөгөөд цэвэр ашиг ₮101 тэрбумд хүрч 21% нэмэгдсэн байна. Өөрийн хөрөнгийн өгөөж 34.4%, активын өгөөж 9.7% байгаа нь салбартаа өрсөлдөх чадвартай түвшинд байгааг харуулж байна.

- **Хувьцааны гүйцэтгэлийн хувьд** 2025 оны эцсийн ханш ₮9,000-д хүрч, IPO хийснээс хойш 5.4 дахин өссөн байна. Компанийн ТУЗ-өөс нэгж хувьцаанд ₮114.9-ийн ногдол ашиг олгохоор шийдвэрлэсэн бөгөөд нийт ₮8.7 тэрбумыг хувьцаа эзэмшигчдэд хуваарилахаар тогтоосон. Хэдий тийм боловч тодорхой шалтгааны улмаас ногдол ашгийн олголтын хугацааг 2026 оны 7 сарын 31 хүртэл хойшлуулсан. Бүртгэлийн өдөр болон ногдол ашгийн хэмжээнд бол өөрчлөлт ороогүй.

Энэ оны төлөвлөгөө: 2026 он нь компанийн 10 жилийн ой тохиож буй онцгой жил бөгөөд бид энэ хугацаанд санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, олон улсын зах зээлд тэлэх, технологид суурилсан шийдлүүдийг нэвтрүүлэх чиглэлээр салбартаа тэргүүлэгч байр суурийг бүрдүүлж чадсан. Ирэх 10

жилд бид хиймэл оюун ухаанд суурилсан автоматжуулалт, дижитал шилжилтийг эрчимжүүлж, ногоон болон тогтвортой санхүүжилтийн чиглэлээр манлайлан ажиллах зорилт тавин ажиллаж байна. Мөн Төв Азийн зах зээл дэх байр сууриа бэхжүүлж, олон улсын хөрөнгийн зах зээлээс санхүүжилт татах боломжийг өргөжүүлэхэд анхаарна.

Эцэст нь хэлэхэд, бид хөрөнгө оруулагч, харилцагч, хамтран ажиллагч талуудынхаа өмнө хүлээсэн үүргээ тууштай биелүүлж, тогтвортой өсөлтийг хадгалсан, технологид суурилсан санхүүгийн байгууллага хэвээр байх болно. Баярлалаа.

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН Ч.ӨНӨРЖАРГАЛ

ТУЗ-ийн 2025 оны үйл ажиллагааны танилцуулгыг ТУЗ-ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны гишүүн Ч.Өнөржаргал хийв. Өнгөрсөн жилийн ХЭХ-ийн шийдвэрээр өөрчлөлт оруулсан ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг танилцуулж, өмнөх хурлаар жижиг хувьцаа эзэмшигчдийг төлөөлсөн гишүүн солигдсоныг дурдав. 2025 оны байдлаар ТУЗ-ийн даргаар Б.Анхболд, ердийн гишүүдээр Д.Баясгалан, Хирохито Намики, Р.Пүрэв хараат бус гишүүнээр Д.Энхбат, Ч.Хашчулуун болон Ч.Өнөржаргал нар улиран томилогдож, шинээр Ш.Эрдэнэбат, Б.Энхмарал нар томилогдон ажилласан байна.

ТУЗ-ийн бүрэлдэхүүн: ТУЗ нь үйл ажиллагаагаа илүү үр ашигтай явуулах зорилгоор нийтдээ Аудитын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Тогтвортой байдлын хороо, Цалин урамшууллын хороо, Эрсдэлийн удирдлагын хороо гэсэн 5 хорооны бүтэцтэйгээр ажилласан байна. Эдгээр хороодод гишүүдийг мэргэжил, туршлагад нь тулгуурлан хуваарилж, багийн зохион байгуулалтаар ажиллуулжээ. Мөн хууль, засаглалын шаардлагын дагуу хороодын даргаар хараат бус гишүүдийг ажиллуулах бодлогыг баримталсан байна.

- **2025 оны ТУЗ-ийн үйл ажиллагаа:** 2025 онд ТУЗ нийт 33 удаа хуралдаж, 69 тогтоол хэлэлцэн баталсан бөгөөд хурлыг ТУЗ-ийн дарга Б.Анхболд удирдан явуулжээ. Гишүүдийн ирц хангалттай байсан бөгөөд асуудлуудыг хүчин төгөлдөр байдлаар шийдвэрлэсэн байна. Хуралдаанаар бизнес төлөвлөгөө, төсөв батлах, компанийн бүтэц шинэчлэх, санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг хэлэлцэх, гадаад эх үүсвэр татах, үнэт цаас гаргах, сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах, охин компани байгуулах, хөрөнгө захиран зарцуулах зэрэг өргөн хүрээний асуудлуудыг хэлэлцжээ. Нийт хурлуудын ихэнх нь цахимаар, үлдсэн нь биет хэлбэрээр зохион байгуулагдсан байна.
- **Аудитын хороо** 2025 онд 19 удаа хуралдаж, 37 дүгнэлт гаргасан бөгөөд дотоод аудит, дотоод хяналтын үйл ажиллагаанд хяналт тавьж, төлөвлөгөө батлах, гүйцэтгэлийг хянах, хөндлөнгийн аудит сонгох, аудитын явцад хяналт тавих, сонирхлын зөрчилтэй хэлцлийг хянах зэрэг үндсэн чиг үүргийг хэрэгжүүлжээ.
- **Эрсдэлийн удирдлагын хороо** хамгийн идэвхтэй ажилласан хороодын нэг бөгөөд 23 удаа хуралдаж, 29 шийдвэр гаргасан байна. Тус хороо нь эрсдэлийн бодлогыг шинэчлэх, тайланг улирал, жилээр хэлэлцэх, их хэмжээний хэлцлийг шийдвэрлэх зэрэг ажлыг гүйцэтгэж, компанийн зээлийн эрсдэлийг бууруулахад чухал үүрэг гүйцэтгэсэн байна.
- **Тогтвортой байдлын хороо** 1 удаа хуралдаж, байгаль орчин, нийгэм, засаглалын (ESG) тайлан болон ногоон санхүүжилтийн бодлогыг баталсан бол цалин урамшууллын хороо 2

удаа хуралдаж, цалингийн бодлого, урамшууллын систем, KPI төлөвлөгөөг хэлэлцэн баталжээ. Нэр дэвшүүлэх хороо 1 удаа хуралдаж, ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын гишүүдийн ур чадвар, туршлагыг үнэлэх, нэр дэвшүүлэх үйл ажиллагааг зохион байгуулсан байна.

2025 онд ТУЗ нь хууль, дүрэм болон компанийн стратегийн хүрээнд үйл ажиллагаагаа хэвийн, хараат бусаар явуулсан бөгөөд хараат бус гишүүд үүргээ хэрэгжүүлэхэд саад бэрхшээл тулгараагүй. Ингээд ТУЗ-ийн 2025 оны үйл ажиллагааны тайлангийн хэсэг өндөрлөж байна.

ЭРНСТ ЭНД ЯНГ МОНГОЛИЯ АУДИТ ХХК-ИЙН ПАРТНЕР МАНДАХБАЯР

Эрнст энд Янг Монголия компани нь дэлхийн 150 улсад 700 гаруй оффистой, 400 мянга орчим мэргэжилтэн ажиллуулдаг, аудит болон мэргэжлийн үйлчилгээний чиглэлээр дэлхийд тэргүүлэгч “Big 4” компанийн нэг юм. Манай компани Монгол Улсад үйл ажиллагаагаа эхлүүлээд 25 жил болж байгаа бөгөөд энэ хугацаанд дотоодын томоохон аж ахуйн нэгжүүд, ялангуяа банк, санхүүгийн байгууллагуудад аудит болон зөвлөх үйлчилгээ үзүүлж ирсэн туршлагатай.

Бид Инвескор групптэй сүүлийн 2 жилийн хугацаанд хамтран ажиллаж, хөндлөнгийн аудитын үйлчилгээ үзүүлж байна. 2025 оны санхүүгийн тайлангийн аудитыг сүүлийн зургаан сарын хугацаанд хийж гүйцэтгэлээ. Аудитын багийг миний бие, аудитын партнер Мандахбаяр ахалж, хамтрагч Адренчу болон нийт 15 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажилласан.

- **Аудитын дүгнэлтийг танилцуулбал:** Инвескор ББСБ болон түүний охин компаниудын 2025 оны 12 сарын 31-ний өдрөөрх группийн нэгтгэсэн санхүүгийн тайлангууд болох санхүүгийн байдлын тайлан, ашиг алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн бодлогын тайлбар болон холбогдох бусад тодруулгуудыг хамруулан аудит хийж гүйцэтгэлээ.
- **Бидний дүгнэлтээр** дээрх санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаарх группийн санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бүх материаллаг талаараа үнэн зөв, бодитойгоор илэрхийлсэн байна.

Мөн бидний олж авсан аудитын нотолгоо нь гаргасан дүгнэлтийг үндэслэхэд хангалттай, зохистой гэж үзэж байгаагаа илэрхийлж байна.

ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Б.БУД

Танилцуулах хэсэг дуусаж, хурлаар хэлэлцүүлэх асуудлуудыг танилцуулж эхлэв.

Эхний асуудал болох ТУЗ-ийн 2025 оны үйл ажиллагаа болон аудитлагдсан санхүүгийн тайланд гаргасан дүгнэлтийг танилцуулъя. ТУЗ-ийн хурлын тогтоолыг товч танилцуулахад, 2026 оны 4 сарын 29-ний өдрийн 26/25 тоот тогтоолоор Компанийн тухай хуулийн холбогдох заалтууд болон компанийн дүрмийг үндэслэн 2025 оны үйл ажиллагаа, санхүүгийн тайланг хангалттай гэж дүгнэсэн бөгөөд уг дүгнэлтийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэн батлуулахыг санал болгосон байна. Мөн уг тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг ТУЗ-ийн нарийн бичгийн даргад даалгасан байна.

- Хуулийн дагуу компанийн жилийн үйл ажиллагаа, санхүүгийн тайланд ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах бүрэн эрх нь ХЭХ-д харьяалагддаг тул уг дүгнэлтийг өнөөдрийн хурлаар батлуулахаар санал оруулж байна. Ингээд та бүхэнд хэлэлцэх эхний асуудлыг танилцуулж дууслаа.

Дараагийн асуудал болох ТУЗ-ийн 2026 оны үйл ажиллагааны төсвийн саналыг танилцуулъя. Энэхүү төсөв нь ТУЗ-ийн гишүүдийн цалин, ажлын албаны зардал, албан томилолт, хурлын зохион байгуулалт, сургалтын зардал болон бусад үйл ажиллагаатай холбоотой зардлуудаас бүрдэж байна. 2026 онд ТУЗ 9 гишүүнтэй ажиллах бөгөөд гишүүдийн цалин, урамшууллыг жилд 12 удаа олгохоор, нийт ₮359.7 саяар төсөвлөсөн байна. Ажлын албаны цалинг нийт ₮30 сая, албан томилолтыг ₮45 саяар төлөвлөсөн.

- Мөн жилийн 4 удаагийн хурлын зохион байгуулалтын зардалд нийт ₮1 сая, сургалтын зардалд ₮5 сая, бусад зардалд ₮5.6 сая тус тус төсөвлөсөн байна. Ийнхүү 2026 оны ТУЗ-ийн нийт төсвийг ₮434.7 саяар батлуулахаар ХЭХ-д санал оруулж байна.

Ингээд хэлэлцэх 3 асуудлын хоёр дахь асуудлыг танилцуулж дууслаа. Одоо 3 дахь асуудал болох компанийн хувьцаа хуваах тухай саналыг Санхүү шинжилгээ, төлөвлөлтийн газрын захирал Г. Цэрэннадмид танилцуулна.

САНХҮҮ, ШИНЖИЛГЭЭ ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛ Г.ЦЭРЭННАДМИД

Компанийн хувьцааг хуваах саналын төслийг танилцуулъя. 2023 оны 4 сарын 14-ний өдөр болсон хувьцаа эзэмшигчдийн хурлаар компанийн нэгж хувьцааг 10 хуваах шийдвэр гарсан. Харин уг шийдвэрийн хэрэгжих хугацаа 2023 оны 12 сарын 31-ний өдөр дуусгавар болсон тул зах зээлийн нөхцөл байдал болон компанийн цаашдын төлөвлөгөөтэй уялдуулан уг саналыг шинэчлэн дахин оруулж ирж байна.

Хувьцааг 10 хувааснаар:

- Зарласан хувьцааны тоо 82 саяас 820 сая ширхэг болно
- Гаргасан хувьцааны тоо 75,744,281-ээс 757,442,810 ширхэг болно
- Нэгж хувьцааны нэрлэсэн үнэ ₮227-өөс ₮22.7 болж буурна

Хувьцаа хуваахын гол давуу тал нь хувьцааны үнийн хүртээмжийг нэмэгдүүлж, жижиг хөрөнгө оруулагчдын оролцоог идэвхжүүлэх, улмаар арилжааны идэвх болон хөрвөх чадварыг дунд, урт хугацаанд сайжруулахад оршино. Харин богино хугацаанд ханшийн хэлбэлзэл нэмэгдэх, мөн компанийн суурь үзүүлэлт сул тохиолдолд сөрөг дохио үүсэх эрсдэл байдаг. Гэсэн хэдий ч манай компанийн хувьд ашигт ажиллагаа болон үндсэн үзүүлэлтүүд тогтвортой өсөлттэй байгаа тул энэ нөлөө харьцангуй бага гэж үзэж байна.

- Инвектор компанийн хувьд 2019 онд IPO хийснээс хойш хувьцааны үнэ 5.4 дахин өсөж, 2025 оны эцсээр ₮9,000-т хүрсэн. Одоогоор зах зээл дээрх өндөр үнэтэй хувьцаануудын нэг хэвээр байна.

Иймд хувьцааны үнийн өсөлтийн хурд саарч эхэлсэн энэ үед хувьцаа хуваах нь зах зээлийн идэвхийг нэмэгдүүлэх зохистой алхам гэж үзэж байна. Энэхүү шийдвэр батлагдсанаар компанийн дүрэмд хувьцааны тоо болон нэрлэсэн үнийн өөрчлөлтүүд холбогдох заалтуудад тусгагдана.

Ингээд өнөөдрийн хувьцаа эзэмшигчдээр хурлаар хэлэлцэн батлуулах нийт 3 асуудлыг танилцуулж дууслаа. Хурлын хөтөлбөрийн дагуу нийт 15 минутын хугацаанд асуулт хариултын хэсэг үргэлжлэв. Асуулт хариултын хэсгийг цахимаар оролцож буй хувьцаа эзэмшигчдээс 3 асуулт танхимаар оролцож буй хувьцаа эзэмшигчдээс 3 асуулт хариулахаар тохирч, асуулт хариултын хэсэгт компанийг төлөөлөөд ТУЗ-ийн дарга Д.Баясгалан, Гүйцэтгэх захирал Д.Оролмаа, Санхүү шинжилгээ төлөвлөлтийн газрын захирал Г.Цэрэннадмид захирал нар оролцов.

АСУУЛТ ХАРИУЛТЫН ХЭСЭГ

Асуулт 1. Төв Азид одоогоор ямар үйл ажиллагаа явуулж байна вэ? Цаашид тэлэх төлөвлөгөө бий юу?

Одоогоор бид Төв Азийн 2 улсад идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

- **Киргизстан** – 2020 оноос бичил санхүүгийн тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Өнөөдрийн байдлаар 6 жилийн туршлагатай, 74 тэрбум төгрөгтэй тэнцэх активтай болж, тогтвортой ажиллаж байна.
- **Казахстан** – 2024 онд тусгай зөвшөөрөл авч, үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Одоогоор хөгжлийн эхний шатандаа явж байгаа бөгөөд ойрын хугацаанд тогтворжино гэж харж байна.

Цаашид Киргизстанд нэмэлт хотуудад тэлэх, Казахстаны Шимкент хотод салбар нээх, Узбекистан болон бусад Төв Азийн зах зээлд нэвтрэх судалгааг үргэлжлүүлэх төлөвлөгөөтэй байна.

Мөн Монголд хуримтлуулсан туршлага, ноу-хау, технологийн шийдлүүдээ Төв Азийн зах зээлд нэвтрүүлэхэд онцгой анхаарч ажиллаж байна.

Асуулт 2. Танай бизнесийн зээл бусад ББСБ-уудаас юугаараа ялгаатай вэ?

Манай компанийн хувьд уламжлалт болон финтек чиглэлийг хослуулан ажилладаг.

Онцлогууд:

- Бизнесийн зээлд төвлөрсөн бодлого (нийт зээлийн ~57%)
- Олон улсын эх үүсвэрийг ЖДБ-д чиглүүлэх үүрэг амлалттай
- Илүү олон жижиг бизнес эрхлэгчдийг хамруулах зорилт
- Ногоон, тогтвортой, эмэгтэй бизнесийг дэмжих тусгай бүтээгдэхүүнүүд

Хамгийн гол давуу тал: Зээлийн шийдвэр гаргах хурд буюу ₮500 сая хүртэлх зээлийг богино хугацаанд шийдвэрлэх боломжтой.

Асуулт 3. Ногдол ашиг тараах хугацаа яагаад өөрчлөгдсөн бэ? Хэзээ олгох вэ?

- ТУЗ хуульд заасны дагуу 2026.02.13-нд шийдвэр гаргасан

- Гэхдээ олон улсын санхүүгийн байгууллагуудтай гэрээний дагуу зөвшилцөх шаардлагатай
- Эдгээр байгууллагууд аудитын тайланг хүлээж байсан

Зөвшилцөл хийгдмэгц ноогдол ашгийг олгоно. 7 сарын 30 бол дээд хугацаа бөгөөд үүнээс өмнө олгох боломжтой.

Асуулт 4 . ТУЗ-ийн зардал яагаад өссөн бэ?

Гол шалтгаан нь

- Сүүлийн 3 жил ТУЗ-ийн цалин өөрчлөгдөөгүй.
- Компанийн хэмжээ, үйл ажиллагаа тэлсэн.
- Хурлын давтамж, ачаалал нэмэгдсэн.
- Төв Азийн үйл ажиллагаатай холбоотой томилолтын зардал нэмэгдсэн.

Асуулт 6. Дунд хугацаанд (1-3 жил) ямар стратеги баримтлах вэ?

Дунд хугацаанд:

- Финтек + уламжлалт ББСБ чиглэлээр манлайлах.
- Гадаад эх үүсвэр таталтыг нэмэгдүүлэх.
- Олон улсын санхүүгийн байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх.
- Төв Азийн тэлэлтийг амжилттай хэрэгжүүлэх.

Гол фокус: Олон улсын тэлэлт

Асуулт хариултын хэсгийн араас санал хураалтын хэсэг 10 минут үргэлжилж дууслаа. Үүний араас санал хураалтын үе шат эхэлж Тооллогын комисс санал өгөх заавар танилцуулав.

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА Б.ЭНХЖИН

Хурлын дэгийн дагуу тооллогын комисс санал хураалтын дүнг нэгтгэн дуусгасан тул хэлэлцсэн асуудал тус бүрээр санал хураалтын дүнг танилцуулж байна. Энэ удаагийн ХЭХ-аар хэлэлцсэн 3 асуудлыг ердийн журмаар санал хураан шийдвэрлэлээ.

1-р асуудал. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланд ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай. Нийт 66,211,025 ширхэг хувьцаа санал хураалтад оролцсоноос:

- Зөвшөөрсөн: 66,200,009 ширхэг буюу 99.98%
- Татгалзсан: 0
- Түдгэлзсэн: 0
- Хүчингүй: 0
- Санал өгөөгүй: 11,016 ширхэг буюу 0.02%

2-р асуудал. ТУЗ-ийн 2026 оны үйл ажиллагааны төсвийг батлах тухай.

- Зөвшөөрсөн: 66,200,009 ширхэг буюу 99.98%
- Татгалзсан: 0
- Түдгэлзсэн: 0
- Хүчингүй: 0
- Санал өгөөгүй: 11,016 ширхэг буюу 0.02%

3-р асуудал. Компанийн хувьцаа хуваах шийдвэрийг шинэчлэн батлах болон компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай.

- Зөвшөөрсөн: 64,603,541 ширхэг буюу 97.57%
- Татгалзсан: 0
- Түдгэлзсэн: 1,596,468 ширхэг буюу 2.41%
- Хүчингүй: 0
- Санал өгөөгүй: 11,016 ширхэг буюу 0.02%

Ингэснээр хурлаар хэлэлцсэн 3 асуудал тус бүр дэмжигдэж, шийдвэрлэгдлээ. Хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдэдээ талархал илэрхийлье.

Талархал ба бэлэг: Инвескор ББСБ-ын зүгээс ХЭХ-д оролцсон хувьцаа эзэмшигчдэд мод үрслэгээний эрхийн бичиг бэлэглэв. Танхимаар оролцож буй хувьцаа эзэмшигчид зохион байгуулалтын багаас бэлгээ хүлээн авсан бол цахимаар оролцсон хувьцаа эзэмшигчид 5 сарын 4-ний өдрийг дуустал Инвескорын төв оффист (IC Tower) хүрэлцэн ирж бэлгээ авах боломжтой.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах тогтоолын төслүүдийг танилцуулснаар хурал 16 цаг 00 минутад хурал өндөрлөв.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



Д.БАЯСГАЛАН

